



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/151НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Нарантуул Утас:99019800 Цахим хаяг: ntuul9800@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 178  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЦЭЦЭГ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
А.ЦОГЗОЛМАА ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэг сумын цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 1,239.1 сая, орон нутгийн төсвөөс 108.7 сая төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч, гүйцэтгэлийн үнэлгээнд 1 дүгээр түвшинд 3 багш, 2 дугаар түвшинд 5 багш, 3 дугаар түвшинд 2 багш, 4 дүгээр түвшинд 1 багш үнэлэгдсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилт 40 арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэн ажилласан байна.

8426050420

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>200,525,637.87</u></b>	<b><u>141,658,803.97</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	106,027,358.57	33,348,600
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	106,027,358.57	33,348,600
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	106,027,358.57	33,348,600
31211	Төрийн сангийн харилцах	106,027,358.57	33,348,600
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	1,236,199.53
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,236,199.53
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	3,666,891.40	3,842,855.54
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	3,666,891.40	3,842,855.54
34713	Цалингийн урьдчилгаа	3,666,891.40	3,842,855.54
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	90,831,387.90	103,231,148.90
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	478,300	254,000
35130	Эм боох материал	478,300	254,000
35300	Бэлэн бүтээгдэхүүн	75,173,887.90	76,958,887.90
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	15,179,200	26,018,261
35410	Бичиг хэргийн материал	927,000	1,271,000
35420	Аж ахуйн материал	759,000	635,000
35460	Хүнсний материал	13,493,200	24,112,261
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,673,406,399.20</u></b>	<b><u>1,615,108,770.28</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,673,406,399.20	1,615,108,770.28
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,660,216,399.20	1,601,918,770.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,763,157,158	1,766,824,049.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(221,016,491.04)	(275,162,383.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	106,201,257	119,018,251
39206	Хуримтлагдсан элэгдэл	(53,489,013.61)	(70,065,062.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	99,066,602	103,636,626
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,482,411.41)	(47,112,008.80)
39217	Ном	4,779,298.26	4,779,298.26
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13,190,000	13,190,000
39301	Програм хангамж	550,000	550,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000)	(550,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,190,000	13,190,000
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,873,932,037.07</u></b>	<b><u>1,756,767,574.25</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,429,619.53</u></b>	<b><u>4,870,223.45</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,429,619.53	4,870,223.45
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,429,619.53	4,870,223.45
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,429,619.53	99,673.45
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,464,050
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	1,306,500
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,306,500
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,696,688,032.54</u></b>	<b><u>1,576,082,965.80</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,696,688,032.54	1,576,082,965.80
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,270,596,067.63	1,149,991,000.89
51210	Өмнөх үеийн үр дүн	1,270,596,067.63	1,270,596,067.63
51220	Тайлант үеийн үр дүн	-	(120,605,066.74)

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	426,091,964.91	426,091,964.91
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,698,117,652.07</b>	<b>1,580,953,189.25</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,371,555,913</b>	<b>1,355,811,294</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>87,141,213</b>	<b>8,002,394</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	87,141,213	8,002,394
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	87,141,213	8,002,394
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	87,141,213	8,002,394
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,284,414,700</b>	<b>1,347,808,900</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,155,850,700	1,239,136,000
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,155,850,700	1,239,136,000
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	22,056,800	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,056,800	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	106,507,200	108,672,900
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,507,200	108,672,900
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,253,347,839.87</b>	<b>1,476,416,360.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,253,347,839.87</b>	<b>1,476,416,360.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,232,860,839.87	1,467,019,056.95
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	828,646,879.88	1,033,470,596.21
210101	Үндсэн цалин	532,613,822.88	637,201,717.51
210102	Нэмэгдэл	242,560,817	305,452,304.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	26,397,354
210104	Урамшуулал	53,472,240	64,419,220
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	104,106,399.75	129,574,761.21
210201	Тэтгэврийн даатгал	70,928,795.11	87,897,285.51
210202	Тэтгэмжийн даатгал	8,286,468.20	10,321,634.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,174,965.93	5,551,753.35
210204	Ажилгүйдлийн даатгал	4,143,234.11	5,160,817.78
210205	Эрүүл мэндийн даатгал	16,572,936.40	20,643,269.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	103,457,577	105,926,096.21
210301	Гэрэл, цахилгаан	5,251,977	7,477,396.21
210302	Түлш, халаалт	98,205,600	98,205,700
210303	Цэвэр, бохир ус	-	243,000
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,361,507.50	-
210401	Бичиг хэрэг	2,851,600	-
210402	Тээвэр, шатахуун	509,907.50	-

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	85,380,460	86,564,689
210502	Хоол, хүнс	85,380,460	86,564,689
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,357,689	3,141,400
210604	Урсгал засвар	5,357,689	3,141,400
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,719,600	2,250,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,351,200	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,368,400	2,250,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	94,830,726.74	106,091,514.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,999,907.18	23,871,476
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,973,200	2,868,500
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,857,619.56	79,351,538.32
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,487,000	9,397,303.79
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,487,000	9,152,900
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,487,000	9,152,900
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	244,403.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	244,403.79
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>118,208,073.13</b>	<b>(120,605,066.74)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>118,208,073.13</b>	<b>(120,605,066.74)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,284,414,700</b>	<b>1,347,808,900.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,284,414,700</b>	<b>1,347,808,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,155,850,700	1,239,136,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,155,850,700	1,239,136,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	22,056,800	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,056,800	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	106,507,200	108,672,900
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,507,200	108,672,900
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,217,168,445.89</b>	<b>1,420,487,658.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,217,168,445.89</b>	<b>1,420,487,658.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,196,681,445.89</b>	<b>1,411,090,354.78</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	827,011,145.89	1,038,486,558.57
210101	Үндсэн цалин	494,481,947.80	623,614,052.39
210102	Нэмэгдэл	266,646,177.70	318,077,679.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	33,450,326.67
210104	Урамшуулал	65,883,020.39	63,344,500.23

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	103,614,900	130,967,800
210201	Тэтгэврийн даатгал	70,458,100	88,973,900
210202	Тэтгэмжийн даатгал	8,289,200	10,530,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,144,600	5,265,500
210204	Ажилгүйдлийн даатгал	4,144,600.	5,135,700
210205	Эрүүл мэндийн даатгал	16,578,400	21,061,800
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	105,167,200	105,926,096.21
210301	Гэрэл, цахилгаан	5,896,000	7,477,396.21
210302	Түлш, халаалт	98,205,600	98,205,700
210303	Цэвэр, бохир ус	1,065,600	243,000
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	95,474,200	96,304,700
210502	Хоол, хүнс	95,474,200	96,304,700
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,340,000	2,502,400
210604	Урсгал засвар	1,340,000	2,502,400
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,425,200	2,250,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,056,800	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,368,400	2,250,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	50,648,800	34,652,800
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,454,000	28,241,200
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,194,800	6,411,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,487,000</b>	<b>9,397,303.79</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,487,000	9,152,900
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,487,000	9,152,900
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	244,403.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	244,403.79
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>67,246,254.11</b>	<b>(72,678,758.57)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	67,246,254.11	(72,678,758.57)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		106,027,358.57
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	106,027,358.57	33,348,600

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,814,385.00	426,091,964.91	1,270,596,067.63	1,872,502,417.54
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>175,814,385.00</b>	<b>426,091,964.91</b>	<b>1,270,596,067.63</b>	1,872,502,417.54
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(122,466,066.74)	(122,466,066.74)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>175,814,385.00</b>	<b>426,091,964.91</b>	<b>1,148,130,000.89</b>	1,750,036,350.80

D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	175,814,385.00	426,091,964.91	1,148,130,000.89	1,750,036,350.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	175,814,385.00	426,091,964.91	1,148,130,000.89	1,750,036,350.80
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(120,605,066.74)	(120,605,066.74)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,814,385.00	426,091,964.91	1,027,524,934.15	1,629,431,284.06

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,450,451,900	1,420,243,254.78
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,450,451,900	1,420,243,254.78
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,441,299,000	1,411,090,354.78
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,060,128,200	1,038,486,558.57
210101	Үндсэн цалин	648,238,300	623,614,052.39
210102	Нэмэгдэл	345,698,600	318,077,679.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	33,450,326.67
210104	Урамшуулал	66,191,300	63,344,500.23
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	130,967,800	130,967,800
210201	Тэтгэврийн даатгал	88,844,100	88,973,900
210202	Тэтгэмжийн даатгал	10,530,900	10,530,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,265,500	5,265,500
210204	Ажилгүйдлийн даатгал	5,265,500	5,135,700
210205	Эрүүл мэндийн даатгал	21,061,800	21,061,800
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	106,170,500	105,926,096.21
210301	Гэрэл, цахилгаан	7,664,800	7,477,396.21
210302	Түлш, халаалт	98,205,700	98,205,700
210303	Цэвэр, бохир ус	300,000	243,000
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	102,626,800	96,304,700
210502	Хоол, хүнс	102,626,800	96,304,700
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,502,400	2,502,400
210604	Урсгал засвар	2,502,400	2,502,400
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,250,500	2,250,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,250,500	2,250,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	34,652,800	34,652,800
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,380,200	28,241,200
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,272,600	6,411,600
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,152,900	9,152,900
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,152,900	9,152,900
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,152,900	9,152,900
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,450,451,900	1,347,564,496.21

<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,341,779,000	1,239,136,000
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,341,779,000	1,239,136,000
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	108,672,900	108,428,496.21
132001	Орон нутгийн төсвөөс	108,672,900	108,428,496.21
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>106,027,358.57</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>33,348,600</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	37	37
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	23	23
620003	Үйлчлэх ажилтан	13	13
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>37</b>	<b>37</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	21	21
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	15

#### **ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :**

Аудитаар нийт 19,721.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13,439.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант онд худалдан авсан 5,325.0 мянган төгрөгийн БҮТЭЗ-ийг зарлагадаж бараа материалын үлдэгдэл зөрүүтэй илэрхийлсэн,
- Бусад тооцооны болон хоолны өглөгийг 4,770.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Боловсролын газраас үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн 1,272.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тайланд тусгаагүй орхигдуулсан,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улс орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн үлдэгдэл 244.4 мянган төгрөгийг тохируулга бичилт хийгээгүй,
- Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлыг, тайлант үеийн үр дүнг 1,826.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 6,282.0 мянган төгрөгийн 6 зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6,282.0 мянган төгрөгийн 6 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2,358.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 3,923.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

#### **3.1 Төлбөрийн акт**

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнеа хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### **3.1.1 Цалин урамшуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын удирдлага нь нягтлан бодогчийн ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дүгээр сарын 29 өдрийн А/13 тоот тушаалаар санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэх үндэслэлээр 1,241,744 (Нэг сая хоёр зуун дөчин нэг мянга долоон зуун дөчин дөрөв) төгрөгийн балансын урамшуулал гэсэн утгаар давхардуулан олгож буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

### **3.1.2 Бараа материалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Хүүхдийн хоногт зарцуулах норм норматив мөрдөөгүй 75.92 кг мах илүү зарцуулсан, махны үлдэгдэлд хяналтын тооллого хийхэд 43.76 кг мах дутсантай холбоотой нийт 1,116,800 төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.” 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/166, А/559, 222 дугаар “норматив батлах тухай” тушаалаар 1.“Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт”-ыг нэгдүгээр, “Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”, гэж заасантай нийцээгүй, “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдээгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

### **3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **3.2.1 Хүүхдийн ирцийн бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Боловсрол мэдээллийн esis.edu.mn системд илгээсэн 2025 оны 03-12 саруудын хүүхдийн ирцийн тоо мэдээг байгууллагын багш нарын өдөр тутамд хөтөлдөг “бүлгийн ирц бүртгэл”-ийн журналын тоотой тулгахад 4934 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын

өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; БШУЯ-ны 2020 оны 3/1557 дугаар албан бичиг "Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем"-ийн [www.esis.edu.mn](http://www.esis.edu.mn) цахим системийг ашиглан бүртгэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Боловсролын мэдээллийн [esis.edu.mn](http://esis.edu.mn) цахим бүртгэлд тухай бүрд мэдээллийг үнэн зөв оруулж, ирцийг бүртгэж хэвших,

### **3.2.2 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын данс бүртгэлд байгаа *asolous* санхүүгийн болон цалингийн программын ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжгүй, *Си Ти Эс ХХК*-ийн санхүүгийн программыг данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж тус тус заасан байна. Ажил гүйлгээ үйл явцыг мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн эсэхээс үл хамааран орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх ба холбогдох хугацааны санхүүгийн тайланд тайлагнана", 14.-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэсэн заалтуудтай нийцээгүй, "үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг данс бүртгэл тусгах

### **3.2.3 Хоол хүнсний материалын зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Хүүхдийн хоол хүнсэнд даршилсан огуурцы, алаг салат, хиам, лечо зэрэг 3,923.5 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг хоол хүнсэнд хэрэглэсэн, шатахууны зарцуулалт хангалтгүй, хоолны зардлаас эцэг эхийн нөхөрсөг уулзалт, хоолны үзэсгэлэнд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;"; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/166, А/559, 222 дугаар "норматив батлах тухай" тушаалаар 1."Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт"-ыг нэгдүгээр, "Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ", нийцээгүй гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Хүүхдийн хоол хүнсэнд шаардлага хангасан бүтээгдэхүүн олгох,

### **3.2.4 Дотоод хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаа санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын багийг томилж, төлөвлөгөөг 2025 оны 9 дүгээр сард батлуулсан хэрэгжүүлээгүй, хүүхдийн хоолны норм норматив мөрдөөгүй, шатахууны зарцуулалт тавих хяналт дотоод хэрэгжүүлээгүй сул, 3 үйлдэлт мауз худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3.6-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ", 3.7-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна" 3.7.1-д "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах", 3.7.3-д "илэрсэн зөрчил, дутагдлын

шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдээдлийг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангах ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шатахууны зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруу лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэг	5	13,439.2	3	6,287.3	2	7,151.9	5	13,439.2	-	-	-	-
Дүн	5	13,439.2	3	6,287.3	2	7,151.9	5	13,439.2				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуулаа	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэг	6	6,912.0	2	2,438.5			4	4,473.5	-	-	-	-
Дүн	6	6,912.0	2	2,438.5	-	-	4	4,473.5	-	-	-	-

**ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-